

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ  
(албан тушаал)



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

(Х.НЯМБААТАР)  
(нэр)

.....  
(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛСАН:

“БАГАЧУУД ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ  
(албан тушаал)



ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

(Б.МӨНХНАСАН)  
(нэр)

2026.01.02  
(огноо)

“БАГАЧУУД ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (Байгууллагын эх үүсвэрээс мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Хариуцах нэгж
<b>Зорилго 1.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго</b> Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.2.10 “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангана.							
<b>Зорилт 1.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт</b> -Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.5.1.“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын							

үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийг хямд, чанартай, эрүүл, аюулгүй дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ. Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө-Хүний хөгжлийн бодлого 182-ын НЗДҮАХ-2.1.2 дахь хэсэгт Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг 10 хувиар нэмэгдүүлж, халдварт бус өвчний тохиолдлыг бууруулах

1.1.	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийлүүлж буй хүнсний хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллана.	-	Хүнсний хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлсэн тоо	119	131	I-IV улирал	Захиргаа, санхүү
1.2.	Байгууллагын нийт ажилчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ, оношлогоонд давтан хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.	Байгууллагын төсөв 10,000.0	Эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо	17	17	I-IV улирал	Захиргаа, санхүү
1.3.	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй биечлэн ажилладаг ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жилд 2 удаа хамруулна.	Байгууллагын төсөв 2,500.0	Нийт ажилчдын тоо	17	17	I-IV улирал	Эрүүл ахуйч
1.4.	Байгууллагын контор, махны болон хуурай хүнсний агуулахууд, хүнсний зориулалттай түгээлтийн автомашинуудыг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг жилд 3 удаа зохион байгуулна.	Байгууллагын төсөв 1,200.0	Ариутгал хийгдсэн тоо	2	3	I-IV улирал	Эрүүл ахуйч, жолооч нар
1.5.	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 85 цэцэрлэг, сургуулиудын эрхлэгч, нярав, тогооч нарын дунд "Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй" сэдэвт сургалт зохион байгуулна. Мөн хамтын ажиллагааг сайжруулж тогооч нарын дунд ур чадварын тэмцээн зохион байгуулна.	Байгууллагын төсөв 6,000.0	Сургалт орсон тоо	1	1	I-IV улирал	Захиргаа, санхүү
1.6.	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан "Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа	-	Хяналт, шалгалт хийсэн тоо	2	4	I-IV улирал	ХАБЭА, дотоод хяналтын ажилтан

	эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журмын дагуу Хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалт, түгээлтэд хийх дотоод хяналтыг чанаржуулна.						
1.7.	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
<p><b>Зорилт 2.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт-</b> Нийслэлийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.4 Ойжуулах, ойн тэлэлт, ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, хамгаалах, замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ. Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний-Эдийн засгийн бодлого 319-ын НЗДҮАХ-3.2.5 дахь хэсэгт Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгийн бүртгэл тооллогыг зохион байгуулж, өмчийн бүрэн бүтэн байдал, эзэмшилд ашиглалтад хяналт тавьж ажиллах, Ногоон хөгжлийн бодлого 380-ын 4.1.4 дэх хэсэг Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих үйл ажиллагааг зохион байгуулна. Засаглалын бодлого 429 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад удирдлагын тогтолцооны реформ хийх замаар засаглалын тогтолцоог оновчтой болгоно. Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 7.3.Төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. 7.3.2.Чадахуйн зарчимд суурилсан оновчтой чиг үүрэг, бүтэц бүхий цомхон чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ.</p>							
2.1.	Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай журмуудыг шинээр болон шинэчилж боловсруулах, хэрэгжилтийг хангах, журмын хяналтын тогтолцоог сайжруулах;	-	Шинээр болон шинэчлэсэн журмын тоо	-	3	I-IV улирал	Захиргаа, санхүү
2.2.	Байгууллагын 2026 оны эдийн засгийн зорилтод түвшинг ханган, ашигтай ажиллагааг нэмэгдүүлэх	-	Төлөвлөсөн ашгийн биелэлтийн хувь	100	100	I-IV улирал	Захирал, ерөнхий нягтлан бодогч
2.3.	Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хамгаалж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг зохион байгуулах	-	Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийн тоо	2	2	I-IV улирал	Ерөнхий нягтлан бодогч
2.4.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, өр, авлага үүсгэхгүй байх, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, үргүй зардлыг хэмнэнэ.	-	Санхүүгийн сахилга батын хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Санхүү
2.5.	“Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг	Байгууллагын төсөв 500.0	Хэвлэмэл хуудас захиалсан тоо	200	200	I-IV улирал	Архив, бичиг хэргийн ажилтан

	захиалах, албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөж хэвших						
2.6.	Албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлнэ.	-	Сургалт зохион байгуулсан тоо	-	2-оос багагүй	I-IV улирал	Архив бичиг хэргийн ажилтан
2.7.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллах	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100	100	I-IV улирал	Архив, бичиг хэргийн ажилтан
2.8.	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	0	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
2.9.	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 2026 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Байгууллагын төсөв 15,000.0	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
2.10.	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
2.11.	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Захирал, ёс зүйн дэд хороо
2.12.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд дээд газар албан тушаалтнаас ирүүлсэн чиглэлийн дагуу мод тарих арга хэмжээг зохион байгуулна.	Байгууллагын төсөв 500.0	Арга хэмжээ зохион байгуулсан тоо	2	2	I-IV улирал	Нийт ажилтнууд

**Зорилт 3.Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт-** Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, НИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 93 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан,

баталгаатай, чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангана. (НИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар дүрэм батлагдсан) Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.2.7. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, кибер аюулгүй байдлыг ханган, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулна, Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө 2026-Зорилтын үр дүн 2.2. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцлийг бүрдүүлж, суралцагчийн хөгжлийг бүх талаар дэмжинэ-Нийслэлийн онцлогт тохирсон хүнсний хангамжийн тогтолцоо, нэгдсэн хангамжийн төв байгуулахад мэргэжил чиг үүргийн байгууллагуудтай хамтран ажиллаж эрүүл баталгаат хоол хүнсээр хангахад дэмжлэг үзүүлж, зөвлөн туслах. Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 4.3. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулна. 7.2.1.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн чанарыг сайжруулна.

3.1.	УИХ, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, дээд газрын үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллана.	-	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Захиргаа
3.2.	2026 онд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгжүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулна. Тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, tender.gov.mn сайтаар нийтэд ил тод зарлан, зохион байгуулна.	-	Багцын тоо	22	27	I-IV улирал	Үнэлгээний хорооны гишүүд
3.3.	Шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, шаардлагатай барааг Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.6 дугаарт зааснаар бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас ирж буй хүнсний бүтээгдэхүүн тус бүрийн итгэмжлэгдсэн лабораторын сорилын дүн, аюулгүй үзүүлэлт бүрэн шинжилгээний бичгийг эх хувиар нь, гарал үүслийн гэрчилгээтэй, шаардлагатай тохиолдолд импортын бүтээгдэхүүний гаалийн мэдүүлгийн гэрчилгээтэй эсэхийг шалган үндэслэн татан авч, стандарт, шаардлагад нийцсэн агуулахад горимын дагуу хадгалж, цэцэрлэг сургуулиудад түгээнэ.	-	Барааны нэр төрлийн тоо	110	120	I-IV улирал	Эрүүл ахуйч, хоол зүйч
3.4.	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн	Байгууллагын төсөв	тоо	2	2		ХАБЭА, дотоод хяналтын ажилтан

	15.1 дэх хэсэг Хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавих, аюулаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгааллын хувцас, ажлын хувцас хэрэгслээр хангана.	8000.0				I-IV улирал	
3.5.	Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох заавар, журмын дагуу хөтөлж, тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Архив, бичиг хэргийн ажилтан
3.6.	2025 оны архивын баримтуудыг хууль, журмын дагуу 2026 оны эхний улиралд багтаан ажилтнуудаас бүрдлийг хангуулан хүлээн авч, "Байнга", "Түр", "70 жил"-ээр ангилан данс бүртгэл үүсгэж, төрөлжүүлэн бүртгэнэ.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Архив, бичиг хэргийн ажилтан
<b>Зорилт 4.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд-</b> Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.2.4.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулж, үйл ажиллагааны уялдаа холбоог ханган мэдээллийн нэгдсэн санд суурилсан технологийн шийдлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлнэ, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний Засаглалын бодлого 444-ийн НЗДҮАХ-5.2.4.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ашигладаг дотоод удирдлагын систем болон дэд системүүдийг хөгжүүлэх.							
4.1.	Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд оруулж, хэрэгжилтийг ханган, хяналтыг сайжруулах;	-	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
4.2.	Байгууллагын <a href="http://bagachuudkhuns.ub.gov.mn/">http://bagachuudkhuns.ub.gov.mn/</a> , <a href="http://shilen.gov.mn/">http://shilen.gov.mn/</a> , цахим хуудсын мэдээллийг тухай бүр шинэчлэх.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
4.3.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын <a href="http://www.erp.ulaanbaatar.mn">www.erp.ulaanbaatar.mn</a> системийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн ашиглана;	-	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV улирал	Захиргаа, санхүү

4.4.	Байгууллагын цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан иргэд олон нийтэд ил тод мэдээлж цахим хуудсанд шинэчлэл сайжруулалт хийх;	Байгууллагын төсөв 15,000.0	Мэдээллийн тоо	12	12	I-IV улирал	ХАБЭА, дотоод хяналт
4.5.	Сул ажлын байрны зарыг өөрийн цахим хуудаст тогтмол байршуулж, сонгон шалгаруулалтыг явуулж байх;	-	Сул ажлын байрыг зарласан тоо	3	3	I-IV улирал	Захиргаа, хүний нөөц
4.6.	Харилцагч аж ахуй нэгж байгууллага болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудаас сэтгэл ханамжийн судалгаа авч түүний мөрөөр үр дүнг тооцож, арга хэмжээ авч ажиллах.	-	Судалгааны тоо	1	2	I-IV улирал	ХАБЭА, дотоод хяналт
4.7.	ISO 9001 чанарын удирдлагын тогтолцооны стандарт нэвтрүүлэх;	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
4.8.	Байгууллагын хяналт, шинжилгээ үнэлгээний тогтолцоо, (KPI)-г сайжруулах;	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Захиргаа, санхүү
4.9.	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх;	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Захиргаа, санхүү

**Зорилт 5.Тохижилтийн хүрээнд-**Орчны тохижилтыг сайжруулж бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж ажиллана.

5.1.	Байгууллагын ажилчдын ажиллах нөхцөл байдлыг сайжруулахад 3 ширхэг иж бүрэн компьютер, 2 ширхэг принтерийг худалдан авах	Байгууллагын төсөв 17,500.0	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Захиргаа
5.2.	Байгууллагын 3 давхар офиссын өрөөнүүд болон хүнсний агуулахад засвар үйлчилгээ хийх	Байгууллагын төсөв 30,000.0	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	Нийт ажилтнууд
5.3.	Байгууллагын архивын нягтаршуулсан шүүгээг засаж сайжруулах	Байгууллагын төсөв 3,500.0	Хэрэгжилтийн хувь	1	100	I-IV улирал	Архив, бичиг хэргийн ажилтан

**Зорилт 6.Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд-**Ханган нийлүүлдэг хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж, харилцагч цэцэрлэг, сургуулиудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллана.

6.1.	Хотын хөгжлийн индекс: 30 (Хүнсний хангамжийн чанар) Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад нийлүүлж буй 32 нэр төрлийн 131 бараа бүтээгдэхүүний эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр захиалгын дагуу тасралтгүй ханган нийлүүлнэ.	-	Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж буй сургууль, цэцэрлэгийн тоо	-	84	I-IV улирал	Эрүүл ахуйч
6.2.	Хотын хөгжлийн индекс: 52 (Хүнсний хангамжийн хүртээмж) Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад хүнсний бүтээгдэхүүний татан авалт, хадгалалт хамгаалалт, түүний боловсруулалтад эрүүл ахуйн талаарх зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ. Илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах ажлыг зохион байгуулна.	Байгууллагын төсөв 1,000.0	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх цэцэрлэг сургуулийн тоо	14	20	I-IV улирал	ХАБЭА, дотоод хяналт, эрүүл ахуйч
<b>Зорилт 7. "2026 оныг Бизнес эрхлэгчдийг дэмжих жил"-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгч бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана.</b>							
7.1.	Бизнес эрхлэгч буюу хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч гэрээт аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж, дотоодын бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлж, хамтарч ажиллана.	-	Уулзалт зохион байгуулсан тоо		1	I-IV улирал	Нийт ажилтнууд
7.2.	Байгууллагын дотоод болон гадаад (сонирхогч талууд) хэлэлцүүлэг зохион байгуулах тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх;		Хэлэлцүүлэг зохион байгуулсан тоо		1	I-IV улирал	Захиргаа, санхүү